

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т
хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2021/06-10-ШТА-ГА

Чойбалсан хот 2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер И.Сэмжидмаа

Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Дэлгэрмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn

Аудитор Я.Зориг

Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn

Аудитор С.Энхбаатар

Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn

Гэрээт аудитор З.Шинэхүү

Утас: 7058-4207, Цахим хаяг: shinekhuuz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн товьёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
БҮЛЭГ 1.УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	7
А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн байна.....	8
А.1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2019 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцэж байна.....	9
А.1.2. Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн байна.....	10
А.1.3 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх ажил хийгдсэн байна.....	11
А.2 Барилга, байгууламжийн зураг, төслийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.....	12
А.2.1 Барилга, байгууламжийн зураг, төслийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.....	12
А.2.2 ТАХ-ний зураг төсөл гүйцэтгэгчид хариуцлага тооцож, 1 ТАХ-ний зураг төслийн санхүүжилтийг олгоогүй байна.....	13
А.2.3 Төсөв батлагдсанаас хойш зураг төслийн магадлал хийгдсэн 7 ТАХ, зураг төслийн дүнгээс төсвийг дутуу баталсан 1 ТАХ байна.....	13
А.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх зохион байгуулалт хангалтгүй байна.....	14
А.3.1 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээнүүд байна.....	14
А.3.2 Хөрөнгө оруулалтын удирдлагын системийн ашиглалт орон нутагт ашиглаж эхлээд байна.....	15
А.3.3 Төсөл арга, хэмжээний санхүүжилт нь хэрэгжих боломжтой байдлаар батлагдсан байна.....	15
А.3.4 Хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж, батлуулсан байна.....	16
БҮЛЭГ 2. ГҮЙЦЭТГЭГЧИД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ДУУСГААГҮЙ, ДУТУУ, ХУГАЦАА ХЭТЭРЧ ГҮЙЦЭТГЭСЭН ЗӨРЧЛҮҮД БАЙСААР БАЙНА.....	16
Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.....	16
Б.1.1. Хөрөнгө оруулалтын ТАХ-нүүдийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.....	17
Б.1.2. ХАА-г төлөвлөгөөнөөс хоцорч зохион байгуулсан ч тайлант хугацаандаа хэрэгжсэн байна.....	17
Б.1.3. Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.....	17
Б.1.4. Тендер шалгаруулалтад оролцогсдын нөхцөл байдлыг бодитой үнэлэхэд анхаарах асуудал байна.....	18
Б.1.5 ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.....	18
Б.2. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, хөрөнгө оруулалтын ТАХ-г чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн зөрчлүүд гарсаар байна.....	19
Б.2.1. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн зөрчлүүд илэрч байна.....	19
Б.2.2. Хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгч тухай бүр арилгаж ажиллаагүй байна.....	22
Б.2.3 Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжүүд техникийн тодорхойлолтод заасны дагуу иж бүрэн байдлаар хэрэглэгчдэд хүрсэн байна.....	22
Б.2.4 Гүйцэтгэгчид нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	22

Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....	23
Б.3.1. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....	23
Б.3.2. Санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс нь дутуу олгосон ТАХ байна.....	23
Б.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 2020 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.	24
Б.4. Барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2019 онд санхүүжилт олгосон 1 төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна..	24
Б.4.1 Барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2019 онд санхүүжилт олгож 2020 онд үргэлжилсэн 1 төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.....	26
Б.4.2 Шинээр ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, 1 тоног төхөөрөмжөөс бусад нь хэвийн ажиллаж байна.....	27
Холбогдох байгууллагын санал:	28
Саналд өгсөн тайлбар:	
ДҮГНЭЛТ:	30
САНАЛ:	31
ЗӨВЛӨМЖ:	32
ТУШААЛ:	33
АЛБАН ШААРДЛАГА.....	35

Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
ДОА	Дорнод аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол Улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БСШУС	Боловсрол, Соёл, шинжлэх ухааны сайд
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг Дарга
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
СТ	Соёлын төв
ЭМ	Эрүүл мэнд
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТОӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
ҮХ	Үнэлгээний хороо



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	"Төсөө батлагдсанаас хойш хийгдсэн зураг, төсөө" /сая.төг/	11
Хүснэгт 2	"Гэрээ байгуулсан хугацаа"	14
Хүснэгт 3	"Улс, орон нутгийн төсвөөс 2020 онд 3-аас дээш ажил авсан ААН-үүд"	15
Хүснэгт 4	"Гэрээний хугацаанд дуусгаагүй, ашиглалтад ороогүй ТАХ"	16
Хүснэгт 5	"Гэрээний хугацаанаас хэтэрч хүлээлгэж өгсөн ТАХ"	18
Хүснэгт 6	"Захиалагч, зохиогчоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт"	23
Хүснэгт 7	"Тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтын дагуу эсэх"	24

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	"Эрх шилжсэн ТАХ, салбараар"	8
Дүрслэл 2	"Эрх шилжсэн ТАХ, нэр төрлөөр"	13
Дүрслэл 3	"ТАХ-ний хэрэгжилт"	16
Дүрслэл 4	"Үүрэг даалгаврын хэрэгжилт"	23

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдэв, МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

“Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газарт хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх,
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад улсын төсвөөс 2020 онд эрх шилжиж ирсэн 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалын дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Гэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар, гэрээт аудитор З.Шинэхүү нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

2117144066
ХТҮ4037 9030891

Аудитын талбарын ажлыг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн УАГ-ын аудитын Гуравдугаар газар болон аймгийн ИТХ, Засаг дарга нарт 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хүргүүлээ.

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн байна.

А.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт Төсвийн тухай хуулиар 2020 онд 11, БСШУС-ын багцаас 7, нийт шинээр хэрэгжүүлэх 18 төсөл, арга хэмжээний эрх шилжиж, хэрэгжсэн байна.

Нийт эрх шилжиж хэрэгжсэн 18 төсөл, арга хэмжээний 13 буюу 72.2 хувь нь боловсрол, соёлын салбарт, 2 буюу 11.1 хувь нь эрүүл мэндийн салбарт, 3 буюу 16.7 нь барилга, бусад салбарт хэрэгжихээр төлөвлөгдсөн байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

Дүрслэл №1. “Эрх шилжсэн ТАХ, салбараар”



Эдгээр ТАХ нь МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцсэн байх шаардлагатай.

Үүнээс МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ хамаардаг тул Дорнод аймагт 2020 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд уг хөтөлбөрт хамаарахгүй байна.

Дээрх төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцсэн байна.

А.1.2 Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3 дахь заалтын дагуу захиалагчдын саналд үндэслэсэн байх шаардлагатай.

Орон нутагт эрх шилжиж ирсэн 24 төсөл, арга хэмжээнээс 23 төсөл, арга хэмжээний саналыг холбогдох төсөвт байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу аймгийн ТЭЗ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн байна.

Харин “Улз голын урсцыг нэмэгдүүлэх “Онон-Улз” төсөл”-ийн саналыг Онон голын сав газрын захиргаанаас УИХ-ын гишүүнд хүргүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

А.1.3 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх ажил хийгдсэн байна.

Улсын төсвөөр 2020 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” мөрдөгдөж байна. Төсвийн тухай хууль болон уг журамд зааснаар аймгийн ТЭЗ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ орон нутгийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцон эрэмбэлсэн байх шаардлагатай.

Улсын төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн эсэхийг үзэхэд 2019 оны 7 дугаар сард аймгийн Засаг дарга, хэлтсийн дарга болон холбогдох мэргэжилтнүүд, агентлагийн дарга нарт улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг танилцуулан, санал авч, эрэмбэлж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

А.2.1. Барилга, байгууламжийн зураг, төслийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.

Барилга, байгууламжийн зураг, төслийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлээгүй дараах ажлууд байна.

- Баянтүмэн сумын цэцэрлэгийн барилгын төсөвт уурын зуухны ажлын 463.0 сая төгрөгийн ажил төсөв тусгагдаагүй байна.
- Баян-Уул сумын соёлын төвийн барилгын төсөвт инженерийн байгууламж /цахилгааны сүлжээ болон дотор, гадна сантехникийн шугамын ажил/-ын 362.0 сая төгрөгийн төсөв тусгагдаагүй байна.

Энэ нь хөрөнгө оруулалтын ТАХ-г жишиг зураг, төсвөөр баталж байгаатай холбоотой бөгөөд тухайн ажлууд хуульд заасан хугацаандаа дуусахгүй, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх сөрөг үр дагаврыг үүсгэж байгаа бөгөөд захиалагч зураг, төслийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, цаашид төсвийг бүрэн батлуулах шаардлагатай байна.

Харин бусад улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний хувьд ажлын даалгаврыг геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэж, иж бүрэн боловсруулсан байна.

А.2.2. Хугацаа хоцорсон 2 ТАХ-ний зураг төсөл гүйцэтгэгчид хариуцлага тооцож, 1 ТАХ-ний зураг төслийн санхүүжилтийг олгоогүй байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хувьд нийт 6 ТАХ-нд 368.5 сая төгрөгийг зураг, төслийн санхүүжилтэд олгохоос 355.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Үүнээс:

- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга /Дорнод, Хэрлэн сум/-ын зураг, төсөлд 28.5 сая төгрөг олгохоос 27.6 сая төгрөгийг олгож, 883.9 мянган төгрөг дутуу олгосон нь 31 хоногийн алданги тооцсонтой холбоотой байна.

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/-ын зураг, төсөлд 25.6 сая төгрөгийг олгохоор гэрээ байгуулсан. Үүнээс зураг төслийн гэрээний дагуу 13.8 сая төгрөгийг олгохоос 13.2 сая төгрөгийг олгож, 578.7 сая төгрөгийг дутуу олгосон нь 45 хоногийн алданги тооцсонтой холбоотой байна. Зураг төсөлд магадлал хийгдэж, ТАХ 2022 он хүртэл хэрэгжих болсонтой холбогдуулан зураг төслийн гэрээний үлдэгдэл төлбөр болох 11.8 сая төгрөгийг 2021 онд зураг төслийн компанид олгохоор шийдвэрлэсэн байна.

Шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд нийт 14 ТАХ-нд 259.0 сая төгрөгийг зураг, төслийн санхүүжилтэд олгохоос 44.3 сая төгрөгийг дутуу олгосон байна. Эдгээр нь дараах шалтгаан, нөхцөлтэй холбоотой байна. Үүнд:

- Төвлөрсөн эрчим хүчний 10кВт шугам сүлжээг 35кВт-аар солих ажлын зураг төсөв /Дорнод, Дашбалбар сум/ боловсруулах ажилд гүйцэтгэгч "Бодит чадал" ХХК нь гэрээнд заасан хугацаанаас 14 хоногоор хугацааг хоцроож, 551.3 мянган төгрөгийн алданги тооцуулсантай холбоотой байна.
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Дорнод, Халхгол сум/ ажилд зураг, төслийг гүйцэтгэгч "Хайдро Дизайн Прожект" ХХК нь гэрээнд заасан хугацаанаас 60 хоногоор хоцроож, 930.0 мянган төгрөгийн алданги тооцуулсантай холбоотой байна.
- Дотуур байрын барилгын их засвар /Дорнод, Булган сум/-ын ажлын зураг, төслийг "Талын хас констракшн" ХХК гүйцэтгэсэн боловч 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан төсөв нь татагдсан 42.8 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.

А.2.3. Төсөв батлагдсанаас хойш зураг төслийн магадлал хийгдсэн 7 ТАХ, зураг төслийн дүнгээс төсвийг дутуу баталсан 1 ТАХ байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 27 төсөл, арга хэмжээний зураг төсвөөс 17 нь ЗГ-ын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах, магадлал хийх дүрэм"-ээр магадлал хийлгэх шаардлагагүй их засвар хийх, тоног төхөөрөмж авах, зураг төсөв боловсруулах ажлууд байна.

Барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах, магадлал хийх дүрэмд, аймгийн ерөнхий архитектораар батлуулж, ТЕЗ болон холбогдох албан тушаалтнуудаар зөвшөөрүүлсэн ажлын зураг төсөвт магадлал хийхээр заасан байна.

Магадлал хийлгэх шаардлагатай 10 төсөл арга хэмжээний зураг төсөвт Барилгын тухай хуулийн 25 дугаар заалтын дагуу магадлал хийлгэж баталгаажуулсан ч Баяндун сумын сургуулийн дотуур байрны барилга, Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн болон конторын барилга, Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлаас бусад 3,636.8 сая төгрөгийн 7 ажлын зураг төсөвт төсвийн тухай хууль батлагдсанаас хойш магадлал хийгдсэн байна. Зураг, төслийн магадлалаар 4 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн байна. Үүнд:

- Цэцэрлэгийн шинэ барилга /Баянтүмэн сум/- Төсөв батлагдсанаас хойш магадлал хийгдэж төсөвт өртөг нь 463.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Соёлын төвийн барилга /Баян-Уул сум/- Төсөв батлагдсанаас хойш магадлал хийгдэж төсөвт өртөг нь 362.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/- Одоогоор 1-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга нь төсөв батлагдсанаас хойш магадлал хийгдэж төсөвт өртөг 234.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/- Төсөв батлагдсанаас хойш магадлал хийгдэж төсөвт өртөг нь 1914.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Зураг төслийн магадлалаар баталгаажуулсан дүнгээс төсвийг дутуу баталсан 1 ТАХ байна.
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Дорнод, Халхгол сум/- Зураг төслийн магадлалыг хууль батлагдахаас өмнө

баталгаажуулсан боловч төсөвт өртөг нь зураг, төслийн дүнгээс 2146.9 сая төгрөгөөр дутуу батлагдсанаас 1000.0 сая төгрөгт багтаан зураг төслийн зарим хэсгийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Зураг төсвийн магадлал хийгдээгүй төсөл, арга хэмжээ батлагдаж байгаа нь төсөл, арга хэмжээний төсөвт өртөг төлөвлөгдсөн дүнгээс өсөх, хөрөнгө оруулалтын ажлын үр дүн болон төсвийн зарцуулалтын үр ашгийг бууруулах үр дагавартай байна.

Энэ нь зураг, төсвийн зохиогчтой гэрээ байгуулсан тохиолдолд гэрээнд тусгагдсан санхүүжилтийг олгох асуудал үүсдэгээс төсөвт тусгагдан батлагдсан ажлуудын зураг төсөвт л магадлал хийлгэж байгаатай холбоотой байна.

Иймд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн зураг төсөвт хуульд заасан хугацаанд магадлал хийлгэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

А.3. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх зохион байгуулалт хангалтгүй байна.

А.3.1 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээнүүд байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 7.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл арга хэмжээ нь төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, ...”, 7.2-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй.” гэж заажээ.

Төлөвлөлтийн зарим шаардлагыг хангахгүй дараах ТАХ-нүүд байна. Үүнд:

1. Зураг төсөв батлагдсан огноог төсвийн тухай хуулийн хугацаатай харьцуулж үзэхэд 2 төсөл, арга хэмжээний зураг төсөл хуулийн хугацаанд боловсруулагдаж бусад 11 төсөл арга хэмжээ 40-126 хоногоор хойшилж батлагдсан байна. Шалтгаан, нөхцөлийг холбогдох мэргэжлийн байгууллага ГХБХБГ-ын даргаас тодруулахад “Төлөвлөсөн ажлууд УИХ болон ИТХ-аар батлагдахдаа хөрөнгө багасгаж батлагддаг. Тэгэхээр зураг төсвийг дахин хийлгэх шаардлага гардаг тул гэрээг батлагдсанаас нь хойш байгуулан ажиллаж байна” гэсэн тайлбар өгч энэ нь үндэслэлтэй байна.

Хүснэгт №1. “Төсөв батлагдсанаас хойш хийгдсэн зураг, төсөв”
/сая.төг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Зураг төсөв хийгдсэн он
1	Дотуур байрны барилгын их засвар /Дорнод, Булган сум/	60.0	2019.12.23
2	Соёлын төвийн барилгын дээвэр, гадна засвар, тохижилт /Дорнод, Чулуунхороот/	80.0	2019.12.23
3	Аймгийн төв номын сангийн уншлагын танхимын засвар /Дорнод, Хэрлэн сум/	24.1	2019.12.23
4	Сургуулийн спорт заалны барилгын засвар /Дорнод, Хэрлэн сум, 12-р сургууль	50.0	2019.12.23
5	Сургуулийн барилгын засвар /Дорнод, Хэрлэн сум, 12-р сургууль/	52.0	2019.12.23
6	Бага сургууль, дунд, ахлах сургуулийн хичээлийн байрны дээврийн засвар /Дорнод, Хэрлэн сум, 8-р сургууль/	45.0	2019.12.23
7	БСУГ-ын барилгын суурийн засвар /Дорнод, Хэрлэн сум/	45.0	2019.12.23
8	“Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Дорнод, Чулуунхороот сум/”	150.0	2019.12.23
9	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/	1,617.8	2020.03.18
10	“Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/	1,138.1	2020.03.18

11	Сургуулийн хичээлийн байрны их засвар /Дорнод, Матад сум/	200.0	2019.12.23
Дүн		3,462.0	

2. Хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөж, батлахдаа нэршил, зориулалт зөрүүтэй хуульд тусгасан дараах төсөл арга хэмжээнүүд байна. Үүнд:

- "Бага сургууль, дунд ахлах сургуулийн хичээлийн байрны дээврийн засвар /Дорнод, Хэрлэн сум, 8 дугаар сургууль/ нь батлагдсан зураг, төсвийн ажлын хүрээнд бага сургуулийн хичээлийн байрны дээврийн засвар болж өөрчлөгдсөн. Батлагдаж ирсэн төсөв нь 60.0 сая төгрөг байсан тул төсөв хүрэлцэхгүйн улмаас бага сургуулийн хичээлийн байрны дээврийг засварлахаар зураг төсвийг нь шинэчилсэн байна.
- "Бага сургуулийн өргөтгөлийн барилгын их засвар /Дорнод, Хэрлэн сум, 1, 5 дугаар сургууль/ нь Дорнод, Хэрлэн сумын 1, 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил болон өөрчлөгдсөн байна.
- "Боловсрол соёл урлагийн газрын суурийн засвар /Дорнод, Хэрлэн сум/ нэртэй батлагдсан боловч дотор заслууд гадаах үүдний довжоо, ажлын байрны өрөөний дотор хана, акустик хавтан, коридорын ханын засвар, хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу шат гэх зэрэг ажлууд хийгдсэн нь төлөвлөхдөө нэршлийг зөрүүтэй хүргүүлсэнтэй холбоотой байна.

А.3.2. Хөрөнгө оруулалтын удирдлагын системийн ашиглалт орон нутагт ашиглаж эхлээд байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журмыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудсыг ашиглалтад оруулсан байна. Орон нутагт төсөл, арга хэмжээг www.publicinvestment.gov.mn цахим системээр дамжуулан эрэмбэлэх үйл ажиллагааг хялбарчилсан байдлаар гүйцэтгэхээр төлөвлөж, цахим систем 2021 оны 04 дүгээр сарын байдлаар орон нутагт ашиглаж эхэлсэн байна.

2020 онд орон нутгийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалтууд зохион байгуулагдаж, улсын хэмжээнд системийн сайжруулалтууд хийгдсэн байна.

А.3.3. Төсөл арга, хэмжээний санхүүжилт нь хэрэгжих боломжтой байдлаар батлагдсан байна.


Аудитын хамрах хүрээний шинээр эрх шилжиж ирсэн 18 төсөл арга хэмжээнээс 1,327.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээний санхүүжилт хугацаандаа олгогдож, ажил нь хийгдсэн байна.

Эдгээрээс он дамжин хэрэгжихээр батлагдсан 6,636.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ дараа онд хэрэгжих боломжтой байдлаар санхүүжилт нь батлагдсан байна.

А.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж, батлуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжихээр эрх шилжиж ирсэн нийт 18 төсөл, арга хэмжээний 5 арга хэмжээ буюу 27.8 хувийг барилга байгууламж, 10 арга хэмжээ буюу 55.5 хувийг их засварын ажилд, 3 арга хэмжээ буюу 16.7 хувийг тоног төхөөрөмж худалдан авах ажилд тус тус зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

Дүрслэл №2. "Эрх шилжсэн ТАХ нэр төрлөөр"



■ Барилга байгууламж ■ Их засвар ■ Тоног төхөөрөмж

Эдгээр төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлууд байна.

Б. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, хөрөнгө оруулалтын ТАХ-г чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн зөрчлүүд байсаар байна.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Б.1.1 Хөрөнгө оруулалтын ТАХ-нүүдийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.

Дорнод аймгийн Засаг даргад 2020 онд 18 төсөл, арга хэмжээний эрхийг холбогдох салбарын сайдуудаас шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.13-д заасны дагуу 2019 оны төсвийн тухай хууль батлагдсан өдрөөс хойших хугацаагаар тооцон үзэхэд захиалагч улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний эрхийг 2020 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн дотор буюу 60 хоногийн дотор шилжүүлэх журмын заалттай.

Хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлэх 18 төсөл, арга хэмжээг 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс 02 дугаар сарын 21-ийг хүртэл буюу 10-30 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна.

Энэ байдал нь худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнөөс оройтож зохион байгуулах, худалдан авах ажиллагаа амжилтгүй болох, хугацаа сунгагдсан тохиолдолд төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх, он дамжих зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

Б.1.2. ХАА-г төлөвлөгөөнөөс хоцорч зохион байгуулсан ч тайлант хугацаандаа хэрэгжсэн байна.

Тендерийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацаанаас оройтож зарласнаас шалтгаалж гэрээ байгуулах хугацаа 22-129 хоногоор хойшилсон дараах ажлууд байна.

Хүснэгт №2. "Гэрээ байгуулсан хугацаа"

№	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээ байгуулахаар төлөвлөсөн	Гэрээ байгуулсан огноо	Хэтэр-сэн хоног	Хэрэг-жилт
---	--------------------------	-------------------------------	------------------------	-----------------	------------

		огноо			
1	Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Дорнод, Халхгол сум/	2020.03.30	2020.04.30	31 ²¹¹⁷¹⁴⁴⁰⁰⁰ ХТҮ4037	Он дамжина.
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/	2020.03.20	2020.06.23	95	Он дамжина.
3	Дотуур байрын барилгын их засвар /Дорнод, Булган сум/	2020.03.01	2020.03.23	22	Дууссан.
4	Сургуулийн хичээлийн байрын их засвар /Дорнод, Матад сум/	2020.04.01	2020.05.12	41	Дууссан.
5	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/	2020.02.01	2020.06.09	129	Он дамжина.
6	Соёлын төвийн барилгын дээвэр, гадна засвар, тохижилт /Дорнод, Чулуунхороот сум/	2020.02.01	2020.03.16	44	Дууссан.
7	Төвлөрсөн эрчим хүчний 10 кВт шугам сүлжээг 35 кВт-аар солих ажлын зураг төсөв /Дорнод, Дашбалбар сум/	2020.05.29	2020.06.30	32	Дууссан.
8	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Дорнод, Чулуунхороот сум/	2020.03.01	2020.05.27	87	Дууссан.

Гүйцэтгэгч компанитай оройтож гэрээ байгуулж байгаа шалтгаан нь холбогдох сайдын багцаас ТАХ-ний эрхийг хугацаа хоцроож шилжүүлсэн, мөн тендерт оролцох аж ахуйн нэгж байхгүйгээс ХАА амжилтгүй болж дахин зарласантай холбоотой байна.

Дээрх хүснэгт №2-ын 3-4, 6-8 дахь ТАХ-нүүд гэрээ оройтож байгуулснаас шалтгаалаад тайлант онд хэрэгжээгүй гэх шалтгаан байхгүй, тайлант онд хэрэгжиж дууссан байна. Харин хүснэгт №2-ын 1-2 болон 5 дахь ТАХ-нүүд он дамжин хэрэгжихээр төлөвлөгдсөн учраас 2021 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.

Дорнод аймагт эрх шилжин зохион байгуулагдсан зарим худалдан авах ажиллагаагаар тендерийн баримт бичигт тусгасан шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна. Тухайлбал:

- “Бага сургууль, дунд, ахлах сургуулийн хичээлийн байрны дээврийн засвар” /Хэрлэн сум, 8-р сургууль/-ын ажилд үнийн санал ирүүлсэн Дорнод хийц ХХК-ийн тендерийн материалд барилгын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралт байхгүй, ТШӨХ-ийн ТӨӨЗ-ын 2.31-д заасан шаардлагыг хангаагүй байхад;
- “Бага сургуулийн өргөтгөлийн барилгын их засвар” /Хэрлэн сум, 1, 5 дугаар сургууль/-ийн ажилд үнийн санал ирүүлсэн ДОЦ ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТӨӨЗ-ын 4.4.(в)2-д заасан шаардлагыг хангаагүй байхад;
- “Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар” /Чулуунхороот сум/-ийн ажилд үнийн санал ирүүлсэн Донж Өргөө ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТӨӨЗ-ын 4.4.(в)3-д заасан шаардлагыг хангаагүй байхад;

¹ “Баталгаажуулсан” гэдэгт сүүлийн 6 сарын дотор нотариатаар баталгаажуулсныг ойлгоно...;

² Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: Шаардлагатай. Үүнд: БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт, БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,

³ Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: Шаардлагатай. Үүнд: БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт, БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер орчны тохижилтын ажил,

- “Дотуур байрны барилгын их засвар” /Булган сум/-ийн ажилд үнийн санал ирүүлсэн Бүжнар ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТӨӨЗ-ын 1.14-д заасан шаардлагыг хангаагүй байхад

Эдгээр нь Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 5.2.4⁵-д заасантай нийцэхгүй байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэж заажээ. Уг заалтаар ҮХ-ний бүрэлдэхүүнд орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ, ЗДТГ-ын төлөөллийг оролцуулна гэсний дагуу оролцуулсан байна.

Аудитын явцад худалдан авах ажиллагааны баримтаас үзэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж хэрэгжсэн “Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нуруу бэхлэх аппарат, түнх болон өвдөгний үе солих мэс заслын суурь багаж” тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын техникийн тодорхойлолтыг хянасан, баталсан холбогдох албан тушаалтны гарын үсэг байхгүй, тамга тэмдгээр баталгаажуулаагүй байна. Энэ нь захиалагч байгууллагаас уг техникийн тодорхойлолтыг ОНӨГ-т баталгаажуулж ирүүлээгүйтэй холбоотой байна.

Иймд тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан оролцогчийг сонгон шалгаруулах, мөн тендерийн баримт бичиг боловсруулахдаа тухайн ажлаас хамааруулан холбогдох тусгай зөвшөөрлийг тусгах нь зүйтэй байна.

Б.1.4. Тендер шалгаруулалтад оролцогсдын нөхцөл байдлыг бодитой үнэлэхэд анхаарах асуудал байна.

Дорнод аймагт эрх нь шилжиж ирсэн 18 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг нээлттэй байдлаар цахим хэлбэрээр зохион байгуулж, тендерийн зарыг өдөр тутмын сонинд тавьсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны талаар өргөдөл, гомдол гараагүй байна.

Аудитын явцад тендер шалгаруулалтын байдлыг үнэлэхэд, аж ахуйн нэгж, компанийн ажиллах хүч, нийт авсан тендерийн тоо, техник, тоног төхөөрөмж зэргийн бодит нөхцөл байдлыг харгалзан үзээгүйгээс тухайн төсөл, арга хэмжээ хугацаа хоцрох, чанаргүй хийгдэх эрсдэл үүсэж байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс 3-аас дээш тооны хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэхээр шалгарсан зарим компаниудын ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №3. “Улс, орон нутгийн төсвөөс 2020 онд 3-аас дээш ажил авсан ААН-үүд”

№	Аж ахуйн нэгжийн нэр	Улсын төсөв /ТАХ-ын тоо/	Гэрээний дүн /сая төгрөг/	Орон нутгийн төсөв, ОНХС /ТАХ-ны тоо/	Гэрээний дүн /сая төгрөг/	НИЙТ ТАХ тоо	НИЙТ төсөв /сая.төг/
1	Бүжнар ХХК	1	59.1	3	262.1	4	321.2
2	Донж өргөө ХХК	2	207.9	2	335.1	4	543.0

⁴ Тендерт оролцогч дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: БА-6.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил, БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

⁵ Тендерийг үнэлэхэд холбогдох хууль болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан заавар, аргачлал, захиалагчийн боловсруулсан тухайн тендерийн баримт бичгийг баримтлах.

3	Ган октаэдр ХХК	1	987.7	7	243.9	8	1231.6
4	Дорнод хийц ХХК	1	42.6	8	247.4	9	290.0
5	Сүхжин ХХК	1	1135.6	2	34.9	3	1170.5

Улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжсэн ТАХ-ний хувьд “Ган-Октаэдр” ХХК, “Дорнод хийц” ХХК, “Сүхжин” ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын чанарт асуудал гараагүй бөгөөд харин “Донж өргөө” ХХК, “Бүжнар” ХХК-ийн гүйцэтгэсэн ажил нь чанаргүй хийгдсэн байдалтай байна.

“Бүжнар” ХХК, Донж өргөө ХХК-ийн хийсэн ажил чанаргүй хийгдсэн нь захиалагчийн албаны хяналтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй байсантай холбоотой байна.

Иймд сонгон шалгаруулалтыг хийхдээ тухайн үеийн нөхцөл байдлыг бодитой үнэлэх нь зүйтэй байна.

Б.1.5. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн нийт 18 тендерийн 9 нь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 8 нь харьцуулалтын аргаар, 1 нь зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журмаар зохион байгуулагдсан байна. Шалгарсан гүйцэтгэгчийн 77.7 хувь буюу 14 нь орон нутгийн гүйцэтгэгч байна.

ТЕЗ нь улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжиж хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Б.2.1. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн зөрчлүүд илэрч байна.

Дүрслэл №3. “ТАХ-ний хэрэгжилт”

Дорнод аймагт шинээр хэрэгжих улсын төсвөөс эрх нь шилжсэн 18, өмнөх оноос шилжиж ирсэн 6 нийт 24 ТАХ байгаагаас 2020 онд хэрэгжиж дууссан 17, он дамжин гүйцэтгэгдэх 4 төсөл, арга хэмжээ байна. Гэрээний хугацаанд дуусаагүй, ашиглалтад ороогүй 3 төсөл, арга хэмжээ байна.




Хүснэгт №4. “Гэрээний хугацаанд дуусгаагүй, ашиглалтад ороогүй ТАХ”

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Хэрэгжилт /хувь/	Гүйцэтгэгч компани	Тайлбар, шалтгаан
1	Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Баяндун сум/	2500.0	41,5	"Вэлмол" ХХК	Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан.
2	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/	1255.0	95	"Дорнын оч" ХХК	Төлөвлөлттэй холбоотой асуудал үүссэн.

3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/	1300.0	95	"Талын сүлд" ХХК	Төлөвлөлттэй холбоотой асуудал үүссэн.
---	--	--------	----	---------------------	--

1. Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/-ийг "Вэлмод" ХХК 2500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 2019-2020 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Үүнээс 2019 онд 1100.0 сая төгрөг батлагдаж, 221.0 сая төгрөг зураг төсвийн зардалд зарцуулагдаж, 879.0 сая төгрөгийг гүйцэтгэлд санхүүжүүлэхээр баталж, төлөвлөсөн боловч зураг төсөв оройтож хийгдсэн шалтгаанаар тухайн онд гүйцэтгэл хийгдээгүй байна. Өнгөрсөн 2020 онд 681.4 сая төгрөгийн гүйцэтгэл хийгдэж, тухайн онд хийгдэх гүйцэтгэлд хүрээгүй учраас 2021 онд нэмж төсөв батлагдаагүй, царцаагдсан байна.



Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төслийн явц - 41,5 хувь

Иймд тус төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаанаас шалтгаалан цаашид хэрэгжихгүй нөхцөл байдал үүссэн нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

2. Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/-ын ажлыг "Дорнын оч" ХХК 1255.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 2019-2020 онд гүйцэтгэж, гүйцэтгэл 95 хувьтай байна. Зураг төсвийн магадлалаар инженерийн байгууламжийн ажил нэмэгдэж, нийт төсөвт өртөг 1797.0 сая төгрөг болж өөрчлөгдөн улсын төсөвт батлагдсан. Үүнээс 2021 онд 542.0 сая төгрөгийн ажил хийгдсэнээр төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусах бүрэн боломжтой байна.



3. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/-ын ажлыг "Талын сүлд" ХХК 2019-2020 онд гүйцэтгэж, гүйцэтгэл 95 хувьтай байна. Зураг төсвийн магадлалаар инженерийн байгууламжийн ажил нэмэгдэж, нийт төсөвт өртөг 1731.9 сая төгрөг болж өөрчлөгдөн улсын төсөвт батлагдсан. Үүнээс 2021 оны төсөвт 50.0 сая төгрөг, 2022 оны төсөвт үлдсэн 381.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь төсөл, арга хэмжээний үр ашгийг бууруулж байна.



Зураг төслийн магадлал хийгдээгүй ТАХ батлагдаж, 3-4 жил дамжин хэрэгжиж байгаа нь барилгын бүтээцэд сөргөөр нөлөөлөхөөс гадна хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг бууруулж байна.

Гэрээ дуусах хугацаанаас хоцроож хүлээлгэж өгсөн дараах ажлууд байна.

Хүснэгт №5. “Гэрээний хугацаанаас хэтэрч хүлээлгэж өгсөн ТАХ”

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Хэтэрсэн хоног /Хүлээж авсан актын огноо/	Гүйцэтгэгч компани	Тайлбар, шалтгаан
1	Бага сургуулийн өргөтгөлийн барилгын их засвар /Дорнод, Хэрлэн сум, 1, 5 дугаар сургууль/	336.8	36	“ДОЦ” ХХК	Гэрээний хугацаанд ажил дууссан тухай хүсэлтийг өгсөн боловч улсын комисс цар тахалтай холбоотой ажлыг оройтож хүлээж авсан байна.
2	Сургуулийн хичээлийн байрын их засвар /Дорнод, Матад сум/	200.0	11	“Өршөөл-тийн ариун” ХХК	1100000 төгрөгийг алданги тооцсон байна.
3	Соёлын төвийн барилгын дээвэр, гадна засвар, тохижилт /Дорнод, Чулуунхороот сум/	80.0	5	“Донж өргөө” ХХК	196587 төгрөгийг алданги тооцсон байна.
4	Төвлөрсөн эрчим хүчний 10кВт шугам сүлжээг 35кВт-аар солих ажлын зураг төсөв /Дорнод, Дашбалбар сум/	100.0	14	“Бодит чадал” ХХК	551294 төгрөгийг алданги тооцсон байна.
5	Бага сургууль, дунд ахлах сургуулийн хичээлийн байрны дээврийн засвар /Дорнод, Хэрлэн сум, 8-р сургууль/	42.6	5	“Дорнод хийц” ХХК	Гэрээний хугацаанд ажил дууссан тухай хүсэлтийг өгсөн боловч улсын комисс цар тахалтай холбоотой ажлыг оройтож хүлээж авсан байна.
6	Дорнод аймгийн Театрт тоног төхөөрөмж худалдан авах	10.0	12	“Дорнын цагаан нуур” ХХК	55000 төгрөгийг алданги тооцсон байна.

Гэрээний хугацаанаас 5-14 хоногоор хугацаа хоцорсон 4 ТАХ-нд нийт 1,892,881.0 төгрөгийг алдангид тооцсон байна.

Аудитын явцад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэхэд гүйцэтгэл дутуу, чанаргүй хийгдсэн дараах ажлууд байна. Үүнд:

1. “Бүжнар” ХХК-ийн 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэсэн “Дотуур байрын барилгын их засвар /Дорнод, Булган сум/-ын ажлын чанар байдалтай газар дээр нь үзэж танилцахад сургуулийн дотуур байрын гадна фасадын ажил дутуу байна. Улсын комисс 2020 оны 05 дугаар сард үүрэг даалгаврын хэрэгжилтээр хүлээн авч, сургуулийн дотуур байрыг холбосон хүзүүвчний барилгын ажил дууссаны дараа фасадын ажлыг гүйцэтгүүлэхээр заасан боловч өнөөдрийг хүртэл дутуу ажлыг гүйцэтгээгүй байна.




Булган сумын сургуулийн дотуур байрны гадна фасадын засвар

2. “Донж өргөө” ХХК-ийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэсэн “Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Дорнод, Чулуунхороот сум/-ын ажлыг газар дээр нь үзэж танилцахад вакум цонх завсартай суугдсан, хаалганы хүрээ салж унасан байдалтай байна. Тухайн ашиглагч байгууллагаас гүйцэтгэгч компанид утсаар мэдэгдэж, компанийн зүгээс зарим чанаргүй хийгдсэн ажлуудыг дахин гүйцэтгэхээр тохиролцсон байна.


Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт:

1. Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын аудитаар “Бүжнар” ХХК-ийн 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэсэн “Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/-ын ажил чанаргүй хийгдсэн тул засварын ажлыг хэсэгчилсэн байдлаар дахин гүйцэтгүүлэхээр албан шаардлагыг өгч ажилласан. Албан шаардлагын биелэлт 2020 оны 12 дугаар сарын байдлаар хэрэгжсэн боловч 2021 оны 04 дүгээр сарын байдлаар сургуулийн гадна фасад 2-3 газарт хуурч унасан байдалтай байна. Сургуулийн зүгээс тухайн компанид мэдэгдсэн боловч одоог хүртэл засварлаагүй байна.



Чойбалсан сумын сургуулийн фасад унасан байдал.

2. “ЦОДММ” ХХК-ийн 496.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэсэн “Сургуулийн барилгын их засвар /Дорнод, Дашбалбар сум/-ын ажлын хувьд албан шаардлагын биелэлт хангалтгүй, тайлант хугацаанд 2-3 удаа ажил гүйцэтгэхээр ирсэн боловч ажилбар дутуу хийгдэж, цонхны тавцан, хана, шалны будаг ховхорч, хууларсан байдалтай хэвээр байна. Барилгын дулаан алдалт буурахгүй байгаа нь гадна фасадын засвар төсөвт тусгаагдаагүй, хана, шалны будгийн ажлын чанар хангалтгүй байгаа нь гүйцэтгэгч компанийн ажлын гүйцэтгэлтэй холбоотой байна.



Дашбалбар сумын сургуулийн барилгын их засварын өнөөгийн байдал


Эрх шилжээгүй ТАХ-ний хэрэгжилт, үр дүнгийн талаар:

1. Соёлын төвийн барилга 250 суудал /Дорнод, Матад сум/, 1500.0 сая төгрөг - “Хөвсгөл геологи” ХХК нь тухайн онд авах санхүүжилтийг бүрэн авсан боловч ажлыг гэрээний хугацаанд буюу 2020 онд дуусгаагүй, компанийн дотоод зохион байгуулалт, хүн хүчний асуудлаас шалтгаалж барилгын явц 75.0 хувьтай байна.



Матад сумын Соёлын төвийн барилгын явц – 75 хувь

2. Бага сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал /Дорнод, Хэрлэн сум, 1, 5 дугаар сургууль/, 1417.9 сая төгрөг - Төсөвт өртөг нь зураг төсвийн магадлалын дүнгээс 75.2 сая төгрөгөөр дутуу батлагдсан байна. Тус 2 барилга ашиглалтад орсон боловч 5 дугаар сургуулийн 3 давхрын 2 ангийн дээврээс ус гоожсон, дотор сантехникийн холбооснууд 3-4 газарт ус алдсан, хойд талын гадна фасадын будаг, 3 давхрын ханын будсан хэсгүүд хуурч унасан байдалтай байна.



Хэрлэн сумын 5-р сургуулийн бага сургуулийн барилга

3. Дотуур байрны барилга 150 ор /Дорнод, Цагаан-Овоо сум/-ын ажил 2019-2022 онд дуусахаар гэрээг сунгасан байна. ТАХ гэрээний хугацаанд дуусахгүй, сунгагдаж байгаа нь зураг төсөл магадлалын дүнгээс 161.0 сая төгрөгөөр дутуу батлагдсантай холбоотой байна.


Хүчин чадал: 150 ор, 1334 м²

Төсөвт өртөг /сая.төг/: 1500.0

Хугацаа: 2019-2022

Гүйцэтгэгч: "Өндөр баганат ХХК

Ажлын явц: 60 хувь



4. Соёлын төвийн барилга 250 суудал /Дорнод, Гурванзагал сум/, 2019-2020 онд дуусаагүй шалтгаан нь төсөвт өртөг зураг төслийн магадлалын дүнгээс 98.0 сая төгрөгөөр дутуу батлагдаж, гүйцэтгэгч компани нь тухайн онд авах санхүүжилтийг бүрэн авсан боловч хүн хүчний асуудлаас шалтгаалж барилгын явц 70.0 хувьтай байна.

Хүчин чадал: 250 суудал, 3340.0 м²

Төсөвт өртөг /сая.төг/: 1500.0

Хугацаа: 2019-2021

Гүйцэтгэгч: "ЦОДММ" ХХК

Ажлын явц: 70 хувь

5. Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Дорнод, Баянтүмэн сум/, төсөвт өртөг нь зураг төслийн магадлалын дүнгээс 82.2 сая төгрөгөөр дутуу батлагдаж, 2020-2021 онд дуусахаар гэрээ байгуулж, ажлын явц 30 хувьтай байна.

Хүчин чадал: 20 ор, 1152.0 м²
Төсөвт өртөг /сая.төг/: 1537.0
Хугацаа: 2019-2022
Гүйцэтгэгч: "Талын сүлд" ХХК
Ажлын явц: 36.4 хувь



6. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Сэргэлэн сум/, 2020-2021 онд дуусахаар гэрээ байгуулж, санхүүжилт болон гүйцэтгэл хэвийн үргэлжилж байна.

Хүчин чадал: 150 ор, 1371.4 м²
Төсөвт өртөг /сая.төг/: 1741.0
Хугацаа: 2020-2021
Гүйцэтгэгч: "ДОЦ" ХХК
Ажлын явц: 24 хувь

Эрх шилжээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-нүүдийн хувьд зарим ажлын гүйцэтгэл хангалтгүй, гэрээний хугацаанд дуусахгүй байгаа нь төсөвт өртөг, зураг төслийн зөрүүтэй байдал, гүйцэтгэгч компанийн хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдал зэргээс шалтгаалж, улмаар он дамжин хэрэгжих, төсвийн үр ашгийг бууруулах зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2020 ОНД АШИГЛАЛТАД ХҮЛЭЭЖ АВСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



Төрийн байгууллагын 1 барилга /Стандартчилал, хэмжилзүйн хэлтэс/



100 ортой 1 дотуур байр, /Баяндун сум/



6 сургуулийн хичээлийн байр, спорт заал, дотуур байрны засвар /Хэрлэн, Булган, Матад сум/



3 ЭМТ, СТ-ийн засвар /Цагаан-Овоо, Чулуунхороот, сум/



2 Төрийн байгууллагын барилгын их засвар /Номын сан, БСУГ/



5 газарт тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Дорнод, Хэрлэн сум БОЭТ, ХДТ, 4, 9, 17 дугаар цэцэрлэг/



1 ажлын зураг төсөв /Дашбалбар сум, эрчим хүч/


Б.2.2. Хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгч тухай бүр арилгаж ажиллаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.11-д заасны дагуу захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

Дүрслэл №4. “Үүрэг даалгаврын хэрэгжилт”

Улсын төсвөөс эрх нь шилжсэн шинээр хэрэгжих 18, өмнөх оноос шилжиж ирсэн 6 нийт 24 ТАХ байгаагаас 2020 онд хэрэгжиж дууссан 17 төсөл, арга хэмжээнээс 3 ТАХ нь тоног төхөөрөмж байна.

Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг авч үзэхэд 14 ТАХ-нээс 8 ажлыг үүрэг даалгавар өгч хүлээн авсан байна.



Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй дараах ажлууд байна.

Үүнд:

Хүснэгт №6. “Захиалагч, зохиогчоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт”

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэсэн компани	Өгсөн үүрэг даалгавар	Тайлбар
1	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга /Дорнод, Хэрлэн сум/	“Их базар констракшн” ХХК	Төв хаалганы хэсгийн халаалтын радиаторыг хэвтээ чиглэлд бэхлэх, зоорины давхрын гадна цонхны саравчийг уртасгах, дээврийн төмөр дарлагын уулзварыг чимхэж битүүмжлэх	Ажлыг 2020.05.26-ны өдөр комисс хүлээн авсан.
2	Дотуур байрны барилга /Дорнод, Баяндун сум/	“Ди Би Ти Би” ХХК	Гадна талбайн тохижилтын ажлыг хийх, халаалтын тогоонд баталгаа гаргаж өгөх	Ажлыг 2020.12.25-ны өдөр комисс хүлээн авч 2021 оны 05 дугаар сард багтаан хийж өгөхөөр үүрэг даалгавар авсан байна.
3	Соёлын төвийн барилгын их засвар /Дорнод, Цагаан-Овоо сум/	“Донж-Өргөө” ХХК	Дээврийн хөндий рүү гарах гарцыг хийх, зуух будах, босоо шугам бэхлэх, цахилгаан самбарын схем байршуулах	Ажлыг 2020.12.15-ны өдөр комисс хүлээн авч 2021 оны 05 дугаар сард багтаан хийж өгөхөөр үүрэг даалгавар авсан байна.
4	Дотуур байрын барилгын их засвар /Дорнод, Булган сум/	“Бүжнар” ХХК	Хойд талын хананы фасадыг хүзүүвчээр холболт хийгдсэний дараа хийж дуусгах	Ажлыг 2020.05.06-ны өдөр комисс хүлээн авсан. Ондоо багтаж хийж өгөхөөр үүрэг даалгавар

				авсан боловч одоо болтол хийгээгүй байна.
5	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Дорнод, Чулуунхороот сум/	"Донж-Өргөө" ХХК	Хаалганы хүрээ модыг бэхлэх, гэрлүүдийг солих	Ажлыг 2020.10.27-ны өдөр комисс хүлээн авсан.

2117144066
ХТҮ4037 5030201

Тайлант онд санхүүжилт татуулахгүй байх зорилгоор, хугацаатай үүрэг, даалгавар өгч хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авдаг жишиг тогтсон байна.

Энэ нь хөрөнгө оруулалтын ажлын үр дүн буурах, хөрөнгө, нөөц үр ашиггүй зарцуулагдах сөрөг үр дагавартай байна.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 4.7 дахь "Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг 14 хоногт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь төсөл, арга хэмжээтэй танилцан үзлэг хийж илэрсэн зөрчил дутагдал арилгуулах үүрэг даалгавар өгч, ашиглалтад хүлээн авсан акт, дүгнэлт гаргасан нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралт "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.16 дахь "Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, захиалагч болон эрх бүхий байгууллагын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй. Энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөрөнгө оруулагч санхүүжилт олгохгүй байж болно." гэж заасантай нийцэхгүй байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжүүд техникийн тодорхойлолтод заасны дагуу иж бүрэн байдлаар хэрэглэгчдэд хүрсэн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд 225.0 сая төгрөгийн 4 ТАХ-ний тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд техникийн тодорхойлолтод заасны дагуу иж бүрэн, эвдрэл гэмтэлгүй нийлүүлэгдсэн байна. Үүнд:

Хүснэгт №7. "Тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтын дагуу эсэх"

№	Төсөл арга хэмжээний нэр, төсөвт өртөг	Төсөвт өртөг /сая.төг/	Техникийн тодорхойлолтод нийцсэн эсэх
1	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нуруу бэхлэх аппарат, түнх болон өвдөгний үе солих мэс заслын суурь багаж	76.0	Тийм
2	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нуруу бэхлэх аппарат, түнх болон өвдөгний үе солих мэс заслын суурь багаж	124.0	Тийм
3	Дорнод аймгийн Хэрлэн сумын 4 9, 17-р цэцэрлэгт хөгжим, техник хэрэгсэл худалдан авах	15.0	Тийм
4	Дорнод аймгийн Театрт тоног төхөөрөмж худалдан авах	10.0	Тийм
		225.0	

Б.2.4. Гүйцэтгэгчид нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэгчид шилжүүлэх санхүүжилтээс гадна тухайн ажлын гэрээний үнийн дүнд багтсан захиалагчийн албаны зардлыг ГХБХБГ-т, зураг төсөл зохиогчийн болон хяналтын зардлыг зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгжид тус тус шилжүүлдэг байна.

ТАХ-ний гүйцэтгэгчид нь өөрийн болон банкнаас авсан зээлийн хөрөнгөөр тухайн ажлыг гүйцэтгэх явцад, эсхүл дууссан үед тодорхой ажлын гүйцэтгэлийг гарган холбогдох үе шатны хяналтаар орсны дараа санхүүжилтийг олгох тухай албан бичгийг захиалагчид хүргүүлсэн байна.

Захиалагч эрх шилжиж ирсэн ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо тухайн ажлын гүйцэтгэлийн баримт, захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт материал, ажлыг хүлээн авсан комиссын дүгнэлт зэргийг үндэслэж олгосон байна.

Аудитын явцад тайлант онд хэрэгжсэн болон дараа онд хэрэгжих ТАХ-ний ажлын гүйцэтгэл, түүний зураг төсөл зохиогч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт болон холбогдох бусад баримт материалаас үзэхэд ТАХ-ний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон гэдгийг харуулж байна.

Мөн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчдийн арилжааны банкин дахь дансны хуулгаас үзэхэд гүйцэтгэгчид нь тухайн төсөл, арга хэмжээнд зориулж зардлыг гаргасан байна. Эдгээрээс үзэхэд гүйцэтгэгчид нь тухайн ТАХ-ний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.3.1. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Захиалагч болон зохиогчийн хяналт нь Барилгын тухай хуулийн 35, 37, 38.1.8, "Барилгын захиалагчийн хяналтын дүрэм"-ийн 2.2, 3.1.4, 3.4, 3.6, 3.12, 3.14 дэх заалтууд, холбогдох яам, агентлаг, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн хэрэгжиж байна.

Зохиогчийн хяналтын зардлыг зураг, төсөв зохиогч хувь хүн, аж ахуйн нэгжид олгосон бол захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБГ-т олгосныг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар 101.4 сая төгрөг, Барилгын хөгжлийн төвд 13.4 сая төгрөг нийт 114.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Барилга хот байгуулалтын яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлөөр ГХБХБГ нь аймгийн төрийн сан болон Барилгын хөгжлийн төвөөс 2019 оны захиалагчийн зардлын нийт 95.5 сая төгрөгийн авлага, 2020 оны захиалагчийн зардлаас 24.5 сая төгрөг нийт 120.0 сая төгрөгөөр машин худалдан авсан байна.

Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ГХБХБГ-аас хяналтын ажлын тайлан, холбогдох материалыг авч гүйцэтгэлийг гүйцэтгэгч болон ашиглагч байгууллагатай хийсэн ярилцлага, ажлын зураг, бодит нөхцөл байдалтай тулган баталгаажууллаа.

Захиалагч нь зураг төсөл зохиогч нартай Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн, 38.1.8 дахь заалтын дагуу зохиогчийн хяналтын гэрээ байгуулан үе шатны ажилбар бүрд хамтран хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус газраас хэрэгжүүлсэн захиалагчийн хяналтын ажлын үр дүнг хангалттай гэж үнэлсэн бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд гарч байгаа зөрчил дутагдал нь гүйцэтгэгч компаниас ихээхэн шалтгаалж байна.

Иймд сүүлийн 3 жилд хийгдсэн аудитаар хөрөнгө оруулалтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн "Бүжнэр" ХХК-д хариуцлага тооцуулах албан шаардлагыг ТЕЗ-д хүргүүлэв.

Б.3.2. Санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс нь дутуу олгосон ТАХ байна.

Аймгийн ЗДТГ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох ёстой.

Дээрх журмын дагуу эрх шилжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 2020 оны бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэхийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. “Ган-Октаэдр” ХХК-ны сумын төвийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Дорнод, халх гол сум/ 2020 оны ажлын гүйцэтгэл 40 хувьтай байхад 20 хувийн санхүүжилт олгосон нь гүйцэтгэлд ногдох дүнгээс 200.0 сая төгрөгөөр дутуу олгосон байна.
2. “Талын сүлд” ХХК-ны Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум / гүйцэтгэл 95 хувьтай байхад санхүүжилтийг 202.6 сая төгрөгөөр,
3. “Дорнын оч” Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян уул сум/ ХХК-ны гүйцэтгэл 95 хувьтай санхүүжилтийг 113.2 сая төгрөгөөр тус тус дутуу олгосон байна.

Энэ нь төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж улсын төсвийн 2020 оны төсвийн тодотголоор дээрх ТАХ-ний санхүүжилт хасагдсантай холбоотой байна.

Б.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 2020 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.

ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны аймагт эрх нь шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд дотоод хяналт шалгалтыг 2021 оны 9, 10 дугаар сард хийхээр төлөвлөгөө, удирдамжид оруулж ТЕЗ-аар батлуулсан байна.

Тус алба нь улсын төсвийн эрх нь шилжиж ирсэн 2019 оны хөрөнгө оруулалтад 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 3 дугаар саруудад дотоод хяналтыг хийсэн ч тайлан эцэслэн дуусаагүй байна.

Сүүлийн 3 жилд хийсэн манай аудитаас харахад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж байгаа хяналт нь цаг хугацааны хувьд оновчтой бус байгаагаас үр дүнд нөлөөлж байна.

Иймд аймгийн Засаг дарга дотоод аудитын төлөвлөгөөг батлахдаа хууль, журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор цаг хугацааг зөв хуваарилж батлах шаардлагатай байна.

Б.4.1. Барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2019 онд санхүүжилт олгож 2020 онд үргэлжилсэн 1 төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.

Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг банкны баталгаа болон урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн олгож, 2020 онд төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг баталгаажуулан Сангийн

яаманд хүргүүлж, тус яамны зөвшөөрлөөр барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгааг чөлөөлөх зохицуулалт хийсэн байна.

Барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2019 онд санхүүжилт олгосон 2 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаандаа дуусаагүй байна. Үүнд:

1. Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/-ийг "Вэлмод" ХХК 2500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 2019-2020 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Үүнээс 2019 онд 1100.0 сая төгрөг батлагдаж, 221.0 сая төгрөг зураг төсвийн зардалд зарцуулагдаж, 879.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж, 681.4 сая төгрөгийн гүйцэтгэл хийгдэж, тухайн онд хийгдэх гүйцэтгэлд хүрээгүй учраас 2021 онд төсөв батлагдаагүй, хугацаандаа хэрэгжээгүй үр дүнгүй ажил болсон байна.
2. Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/-ын ажлыг "Дорнын оч" ХХК 1255.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 2019-2020 онд гүйцэтгэж, гүйцэтгэл 95.0 хувьтай байна. 2019 онд 455.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Үүнээс гүйцэтгэлээр 312.3 сая төгрөг, урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 136.7 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 30.0 хувийг, 2020 онд 827.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Зураг төслийн магадлалаар инженерийн байгууламжийн ажил нэмэгдэж, нийт төсөвт өртөг 1797.0 сая төгрөг болж өөрчлөгдөн улсын төсөвт батлагдсан. Үүнээс 2021 онд 542.0 сая төгрөгийн ажил хийгдсэнээр төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусахаар байна.

Барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2020 оны төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгогдоогүй байна.

Б.4.2. Шинээр ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, 1 тоног төхөөрөмжөөс бусад нь хэвийн ажиллаж байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар батлагдаж аймагт эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр ашиглалтад орсон 2 барилга, БСШУЯ-ны багцаас 5 байгууллагад нийлүүлсэн тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын эзэмшилд шилжүүлж, бүртгэл, тайланд тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 оны хичээлийн жилд 100 хүүхдийн хүчин чадалтай Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр ашиглалтад орсон ч "Ковид" цар тахлаас шалтгаалан бүрэн хүчин чадлаараа ашиглагдахгүй байна. Цаашид хичээлийн үйл ажиллагаа жигдрээд ирэхэд бүрэн хүчин чадлаараа ажиллахаар байна.

Стандарт хэмжил зүйн барилга ашиглалтад орсноор хэмжил зүй, стандартчилал, сорьцын хяналт, тохирлын үнэлгээний үйл ажиллагааг олон улсын хөгжлийн чиг хандлага, жишигт ойртуулах, төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хурдан шуурхай хүргэх таатай нөхцөл бүрдсэн байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нуруу бэхлэх аппарат, түнх болон өвдөгний үе солих мэс заслын суурь багаж нийлүүлэгдсэн боловч ашиглагдахгүй байна. Ажиллуулахгүй байгаа шалтгаан нь өвдөг түнхний үений "эмплант" багаж улсын хэмжээнд тасарсантай холбоотой байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21080 Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

2021.04.28 № 1/810
танай 2021.04.26-ны № 399 -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Б.Болортуул:
Майланин саналыг хэлэлцэж
эцэслэж ЧАСТ хүргүүлэв.
2021.04.29
Б.Болортуул

Таны 2021 оны 399 дүгээр албан бичгээр ирүүлсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тус тайланд зөрчлөөр тусгагдсан зарим асуудал нь бидний үйл ажиллагаанаас шалтгаалаагүй бөгөөд дээд шатны байгууллагуудын үйл ажиллагаа, ажлын зохион байгуулалттай холбоотой үүссэн байх тул дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

А.2.1. Барилга байгууламжийн зураг төслийн ажлын даалгаварыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.

Аудитын тайлан дахь ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлээгүй зөрчилд хамаарах Баянтүмэн сумын цэцэрлэг болон Баян-Уул сумын Соёлын төвийн барилгуудын 2020 оны төсөвт тусгагдаагүй ажлууд нь зурагт бүрэн тусгагдсан бөгөөд батлагдсан төсвийн дүнд тааруулан тухайн онд хийх ажлын хэмжээгээр худалдан авалтыг зарлаж ажлыг гүйцэтгүүлсэн.

Хөрөнгө оруулалтын ажлыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэх зорилгын улмаас дээрх тусгагдаагүй гэх ажлуудын төсвийн саналыг батлагдсан зургийн дагуу боловсруулан Сангийн яам болон холбогдох яаманд хүргүүлж 2021 оны улсын төсөвт батлуулсан болно.

А.3.2. Хөрөнгө оруулалтын удирдлагын мэдээллийн систем ашиглалт орон нутагт эхлэл төдий байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын мэдээллийн систем 2019 онд анх нэвтэрч эхэлсэн бөгөөд жил бүр программын сайжруулалт хийсээр 2021 оны 4 дүгээр сард Сангийн яамнаас зохион байгуулсан сургалтаар сүүлийн хувилбарыг хэрхэн ашиглах зөвлөмж өгөгдсөн. Өмнөх онд программын өгөгдөлд нийцүүлэн 2021 оны улсын төсөвт тусгах ажлын саналыг тус системд бүрэн оруулсан бөгөөд одоо 2022 оны улсын төсөвт тусгах саналыг зөвлөмжийн дагуу оруулж байна.

Б.3.2. Санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс нь дутуу олгосон төсөл, арга хэмжээ байна.

Энэхүү асуудал нь Улсын Их Хурлаар баталсан 2020 оны төсвийн тодотголоор зарим төсөл, арга хэмжээний тухайн онд санхүүжих төсөвт өртөг хасагдсан, 2020 оны эцэст Сангийн яаманд хүргүүлсэн гүйцэтгэлийн санхүүжилт бүрэн олгогдоогүй зэргээс шалтгаалсан болно.

010521473



Зураг төсвийн 11.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон нь тухайн ажлын тайлант оны батлагдсан төсөв дэх гүйцэтгэлтэй холбоотой бөгөөд дутуу санхүүжилт нь 2021 оны ажлын гүйцэтгэлээр олгогдохоор байна.

Мөн батлагдаагүй техникийн тодорхойлолтыг худалдан авах ажиллагаанд баримталсан гэсэн асуудлын тухайд "Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нуруу бэхлэх аппарат, түнх болон өвдгийн үе солих мэс заслын суурь багаж тоног төхөөрөмж" нийлүүлэх ажлын техникийн тодорхойлолт нь батлагдсан хувь нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст байгаа бөгөөд БОЭТ-ийн дээрх тоног төхөөрөмжийн нэг нь ашиглалтгүй байгаа нь ашиглалтад шаардагдах материал улсын хэмжээнд тасарсантай холбоотой бөгөөд захиалагчаас шалтгаалаагүй болно.

"Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг баримтлах" тухай зөвлөмжид хамаарах нөхцөл байдал нь тайланд эрхийг оройтож шилжүүлснээс шалтгаалсан талаар тусгагдаж тухайн эрх шилжүүлсэн газарт хандах талаар Үндэсний аудитын газарт хүргүүлэх саналын хэсэгт тусгагдсан байна.

Иймд тайлангийн 3, 4, 6 дугаар зөвлөмжийг хасуулж дээрх тайлбарт хамаарах нөхцөл байдал болон дүгнэлтийг өөрчлүүлэх хүсэлтэй байна.

Цаашид Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас өгч буй зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН



ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

1. А.2.1 дэх асуудал нь 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хамааралтай тул улсын хэмжээнд нэгтгэгдэх тайланд хэвээр үлдээлээ.
2. А.3.2 дахь асуудлын илэрхийлэлтэд өөрчлөлт оруулж тайланд тусгалаа.
3. Б.3.2 дахь асуудлын нөхцөл байдал, шалтгааныг тайланд тусгасан тул хэвээр үлдээж ҮАГ-аар дамжуулж Сангийн яаманд хүргүүлэх саналаар орууллаа.
4. Б.4.2 дахь асуудлыг хүлээн авч тайланд өөрчлөлт орууллаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцсэн байна.
2. Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн байна.
3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх ажил хийгдсэн байна.
4. Барилга, байгууламжийн зураг, төслийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй 825.0 сая төгрөгийн зөрчил байна.
5. Хугацаа хоцорсон 2 ТАХ-ний зураг төсөл гүйцэтгэгчид хариуцлага тооцож, 1 ТАХ-ний зураг төслийн санхүүжилтийг олгоогүй байна.
6. Төсөв батлагдсанаас хойш зураг төслийн магадлал хийгдсэн 7 ТАХ, зураг төслийн дүнгээс төсвийг дутуу баталсан 1 ТАХ байна.
7. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээнүүд байна.
8. Хөрөнгө оруулалтын удирдлагын системийн ашиглалт орон нутагт ашиглаж эхлээд байна.
9. Төсөл арга, хэмжээний санхүүжилт нь хэрэгжих боломжтой байдлаар батлагдсан байна.
10. Хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.
11. Хөрөнгө оруулалтын ТАХ-нүүдийг холбогдох яамдаас хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.
12. ХАА-г төлөвлөгөөнөөс хоцорч зохион байгуулсан ч тайлант хугацаандаа хэрэгжсэн байна.
13. Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.
14. Тендер шалгаруулалтад оролцогсдын нөхцөл байдлыг бодитой үнэлэхэд анхаарах асуудлууд байна.
15. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.
16. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, хөрөнгө оруулалтын ТАХ-г чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн зөрчлүүд илэрч байна.

17. Хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгч тухай бүр арилгаж ажиллаагүй байна.
18. Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжүүд техникийн тодорхойлолтод заасны дагуу иж бүрэн байдлаар хэрэглэгчдэд хүрсэн байна.
19. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
20. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.
21. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс нь дутуу олгосон байна.
22. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 2020 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.
23. Барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2019 онд санхүүжилт олгосон 1 төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.
24. Шинээр ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, 1 тоног төхөөрөмжөөс бусад нь хэвийн ажиллаж байна.


Аудитаар нийт 7,923.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3,636.8 сая төгрөгийн 5 албан шаардлага, 4,287.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 6 саналыг хүргүүлээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Магадлалаар баталгаажсан зураг төсвийн дүнг үндэслэлгүй багасгаж баталж байгааг холбогдох яамдад санал хүргүүлэх.
2. Орон нутагт төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлэхдээ журамд заасан хугацааг мөрдөж ажиллахыг холбогдох газарт хүргүүлэх.
3. Төсөл, арга хэмжээний нэршлийг хуулиар батлахдаа өөрчилж баталж байгааг холбогдох газар санал хүргүүлэх.
4. Төсөл, арга хэмжээ болон зураг төсвийн санхүүжилтийг олгоогүй буюу бодит гүйцэтгэлээс нь дутуу олгож байгаа асуудлыг эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэх талаар холбогдох газар санал хүргүүлэх.
5. Он дамжин 2019 оноос хойш хэрэгжиж дуусаагүй, зорилтот үр дүнд хүрээгүй "Вэлмот" ХХК-д ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14.1.4 дэх заалтын дагуу хариуцлага тооцуулах, төсвийн үр ашгийг бууруулж байгаа ТАХ-нүүдэд хяналтыг хэрэгжүүлж, санхүүжилтийг эхний ээлжид шийдвэрлэж, ашиглалтад оруулах талаар холбогдох чиглэлийн яаманд санал хүргүүлэх.
6. Эрх нь шилжээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилт хангалтгүй аж ахуйн нэгжүүдэд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14.1.4 дэх заалтын дагуу хариуцлага тооцуулах асуудлыг холбогдох чиглэлийн яаманд хүргүүлэх.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд зөвлөж байна. Үүнд:

1. Барилга, байгууламжийн зураг, төсвийн ажлын даалгаврыг боловсруулах ажлыг хууль, журамд заасны дагуу зохион байгуулах.
2. Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 7.1 дэх "Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл арга хэмжээ нь төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, ...", 7.2-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
3. Тендер шалгаруулалтад оролцогчдын тухайн үеийн нөхцөл байдлыг бодитой үнэлэхэд анхаарч ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2021 оны 11 дугаар сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 07

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын аудитын Гуравдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга М.Энхтөр, Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011012032

Тэргүүлэх аудиторын 2021 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 07 тоот тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

2021.04.29.

№	Байгууллагын нэр	Аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/06-10-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	3,636.80
2	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/06-10-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-
3	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/06-10-ШТА-ГА	Хариуцлага тооцуулах тухай	-
4	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/06-10-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-
5	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/06-10-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-
Нийт дүн				3,636.80



2021-09-28

ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ ТУХАЙ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Улсын төсвийн 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Дотуур байрны барилгын их засвар (Дорнод, Булган сум)", 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар (Дорнод, Чулуунхороот сум), 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга (Дорнод, Хэрлэн сум), 2500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Улз голын урсгыг нэмэгдүүлэх Онон-Улз төсөл" (Дорнод, Хэрлэн сум) зэрэг ажлууд чанаргүй, дутуу гүйцэтгэгдсэн, үүрэг даалгавар, гэрээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь ТБОНХБАУХАТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх "Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцоходоо гэрээний үүрэгээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэрэгжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон", 52.1 дүгээр зүйлийн 52.1.1 дэх "Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий улсын ахлах байцаагч, улсын байцаагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байна". Засгийн газрын 2018 оны 317 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 4.7 дахь "Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрэн зөрчил дутаагдлыг 14 хоногт багтаан арилгаж, комиссын хурлаарнаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хянаж, шаварлагатай барилгын бичгийг бүрдүүлэх". Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.14 дэх "Барилгын ажлыг барилга байгууламжийн зураг төсөл, норм, нормативын баримт бичиг болон техникийн нөхцөлд зөрчиж чанаргүй, эсхүл дутуу гүйцэтгэсэн нь барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, дүнгэлт, шатламжлагдсан лабораторийн шинжилгээгээр тогтоосонд тохиролдод захиалагч барилгын ажлыг түр зогсоож, тухайн зөрчил дутаагдлыг гүйцэтгэгчийн

011041225



2021-09-28

ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ ТУХАЙ

Хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын аудитаар "Бүжнэр" ХХК-ийн 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэсэн "Сургуулийн барилгын их засвар (Дорнод, Чойбалсан сум)-ын ажлыг 2020 онд хэсэгчилсэн байдлаар дахин гүйцэтгэсэн боловч 2021 онд сургуулийн фасад дахин засварлах нөхцөл үүсгэнийг засварлаагүй, 2020 оны "Дотуур байрны барилгын их засвар (Дорнод, Булган сум)-ын ажлыг дутуу, гүйцэтгэж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй" "ЦОДММ" ХХК-ийн 496.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэсэн "Сургуулийн барилгын их засвар (Дорнод, Дашбалбар сум)-ын ажлыг дахин гүйцэтгүүлэх талар албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа нь Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйл 350.1.1 дахь "Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх", 350.1.7 дахь "Ажлын үр дүнийн доголсныг арилгахад шаарддаг зардлыг (ажлын хөлс, материалын зардал, замын хураамж, болон тээврийн хөлс г.м) хариуцах", 352 дугаар зүйлийн 352.1 дэх "Ажил гүйцэтгэгч эзрээгээр талууд хүлээсэн үүрэг гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд энэ хуульд заасан нийтлэг журмыг үйлчилнэ", 352.2.1 дэх "Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол ажил гүйцэтгэгчийн санхүүгээр түүний зардлаар үз доголсныг ариулуулах, эсхүл ажлын шинээр гүйцэтгүүлэх", 352.2.2 дахь "Доголсныг ариулуулахаар тогтоосон хугацаанд ажил гүйцэтгэгч ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол захиалагч үз доголсныг ариулаж, түүнийг холбогдсон зардлаа нөхөн төлүүлэх", 353 дугаар зүйлийн 353.2 дахь "Гэрээнд заасан тоо хэмжээ, чанарыг тохирч байвал ажлын үр дүн биет байдлын доголдолтой гэнэ", ТБОНХБАУХАТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх "Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцоходоо гэрээний үүрэгээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэрэгжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон", Сангийн сайдын 2018 оны 282 дугаар тушаал "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арг-хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 17.7 дахь "Гэрээний

011041225

зардлаар зогсоулах, дутуу ажлыг гүйцэтгэж хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг арга хэмжээг авна. Гүйцэтгэгч зөрчлийг арилгаагүй тохиолдолд барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын" 4.2.1.8-4.2.1.9, 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Булган сумын сургуулийн дотуур байрны барилгын их засварын ажлыг дутуу гүйцэтгэсэн "Бүжнэр" ХХК, Чулуунхороот сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлыг чанаргүй, үүрэг даалгаврыг дутуу гүйцэтгэсэн "Донж өргөө" ХХК, Улз голын урсгыг нэмэгдүүлэх Онон-Улз төслийн гэрээний хугацааг баримтлаагүй, дутуу гүйцэтгэсэн "Вэлмэт" ХХК, Стандарт-хэмжил зүйн хэлтсийн барилгын ажлыг үүрэг даалгаврыг дутуу гүйцэтгэсэн "Их базар констракшн" ХХК-иудад хугацаатай үүрэг даалгавар өгөх.
2. Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгаж.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
АХЛАХ АУДИТОР Б.ДЭЛГЭРМАА
АУДИТОР Я.ЗОРИГ

талууд нь гэрээнд заасан үүрэгээ биелүүлээгүй бол гэрээ болон холбоодох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ноёдуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын" 4.2.1.8-4.2.1.9, 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг чанаргүй, үүрэг даалгаврыг дутуу буюу хангалтгүй хэрэгжүүлсэн "Бүжнэр" ХХК, "ЦОДММ" ХХК-иудад хариуцлага тооцох.
2. Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгаж.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
АХЛАХ АУДИТОР Б.ДЭЛГЭРМАА
АУДИТОР Я.ЗОРИГ

394/4110, 394, 262/16, 10, 404, 16

Зөрчил орхилох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд МҮЕА-ын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөөнийг хэрэгжилт, үр дүн, үр ашгит" хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгийг оруулалтаар 2019-2020 онд нэг нь шилжээ ирсэн 3636.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ /Үндс: 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Стандарт хэмжээт зүйн хэлтсийн барилдаа" /Дорнод, Хэрлэн сум/, 1300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Цэцэрлэгийн барилдаа, 150 ор" /Дорнод, Баянтүмэн сум/, 1255.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Солёнгийн төвийн барилдаа, 250 суудал" /Дорнод, Баган-уул сум/, 336.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Бага сургуулийн өргөтгөлийн барилгын их засвар" /Дорнод, Хэрлэн сум, 1. 5 дугаар сургууль/, 1617.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Солёнгийн төвийн барилдаа, 200 суудал" /Дорнод, Булган сум/ 1139.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор" /Дорнод, Хэрлэн сум/, 2500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Улз голын урсгийг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл" /Дорнод, Хэрлэн сум/ зэрэг нийт 7 төсөл, арга хэмжээний зурга төсвийн мэдээлэл нь 2019, 2020 оны төсвийн тухай хууль батлагдсанаас хойш хийгдэж, батлагдажсан байна.

[illegible]

дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 6 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-г "Шалвардагч этгээд кууль тогтоохыг, захиргааны хэмжээний болон бусад эрх зүйн акт зарсч, кууль хүлээн авч үүрэг биелүүлэх бол алва. зөрчилд таслан зогсоох, даатган гаргуулахыг бий талын байгууллага, албан тушаалтан албан шалвардагч өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 16/9 дүгээр аудитын батлагдсан "Албан шалвардагч өгөх акт" тогтоох журмын 4.2.1.8, 4.2.1.11-д заасныг үндэслэн ШААРДАЛ:

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ

АХЛАХ АУДИТОР Б.ДЭЛГЭРМАА

АУДИТОР  Я.ЗОРИГ

011041231

1961-04-20 100/ART-200/06-078-1A

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх болон хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу "Урсан төсвийн 2020 оны хөрөнгө орууллагын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг" гүйцэтгэлийн аудит хийх ачаад дараах зөрчин илэрлээ. Үүнд

Дорнод аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шийдмн зохион байгуулагдсан зарим худалдан авах ажиллагаагаар төндөрийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна. Үүнд:

- “Бага сургууль, дунд, ахлах сургуулийн хэлтсийн багш нарын завсар” /Хэлтэс сүм, 8-р сургууль/–ын ажилд үүнийг санал иргүүлэн Дорнод хийд ХХК-ийн төндрийн материалд барилгын тугайг зөвшөөрлийн хүчинтэй кутлага дусон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хавсралт байхгүй ТШХ-ийн ТОБЗ-ын 2.3-т заасан шаардлагад хянаагүй байхад.
- “Бага сургуулийн өргөлтийн” барилгын их завсар /Хэлтэс сүм, 1, 5 дугаар хороо/–ын ажилд үүнийг санал иргүүлэн Дорнод хийд ХХК-ийн төндрийн багш бичигч ТШХ-ийн ТОБЗ-ын 4.4 (а,г)-т заасан шаардлагад хянаагүй байхад.
- “Зүүл мэндийн төвийн барилгын их завсар” /Алчуурхорол сүм/–ын ажилд үүнийг санал иргүүлэн Донго ХХК-ын төндрийн барилгт бичигч ТШХ-ийн ТОБЗ-ын 4.4 (г)-т заасан шаардлагад хянаагүй байхад.
- “Дотуу байрны барилгын их завсар” /Булган сүм/–ын ажилд үүнийг санал иргүүлсэн Чонгод ХХК-ын төндрийн барилгт бичигч ТШХ-ийн ТОБЗ-ын 1.1-1-ээс заасан шаардлагад хянаагүй байхад.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлний 47.2-й "Тэнгизийн орон буйнгын бараа ажиллагаатай байх байдод дор дуралсан ч үүргээтэй байх". 47.2.1-д "техникийн тодорхойлолт багтаах" тэндерийн урилга, тэндерийн баримт бичгийг боловсруулах, тэндэр хүлээн авах, тэндэр нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх". Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тусгай урилгайн 1 дүгээр хэсэглэлээр баталсан "Тэнгизийн хөрөнсыг зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах"

[illegible]

журам"-ын 5.2-т "Үнэлгээний хороо хуулийн 47.2 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дараахь журам, зааврыг мөрдөж ажиллана", 5.2.4-д "Төндөрийг үнэлэхэд холбогдох хууль болон төсвийн асуудал эрхлэсэн Засгийн газрын гишүүний баталсан заавар, аргачлал, захиалгачийн болосворуулсан тухайн төндөрийн баримт бичгийг баримтлах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна

Иймд Төрийн бодлогын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шааргддаг атгалд тулготгоос, заавиргааг хам хэмжээний болон бүлэглэлд эх үйс ажил эр зорсон, хуулийг хяналтсан албан үндэс бүлэглэлгүй бол алдаа, зөрчилгүй таслан зоогоо даатан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн ажил тогтоох журам" -ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дарах үйлдлийн үндэслэлийг харгалзан Үүнд: 4.2.1.8-д "Байгуулсан гэрээ, хэлэлц хэлбэлдээ дүрэм, журмыг баримтлуулах", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ үзүүлэх үйлдлийг", 4.2.1.10-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлэлц зөрчсөн алдаа зөрчилгүй таслан зоогсох, даатан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заагныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА

АУДИТОР: С.ЭНХБААТАР

011041236



2021-09-18

МУА/19235/2021-09-18-178-178

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх болон хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашгаа"-г хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэртээ. Үүнд:

Аймгт эрх нь шилжиж хэрэгжсэн 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд хяналт шалгалтыг хийгээгүй байгаа бөгөөд хуулийн 3 жилд хийсэн манай аудитаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь "төрийн аудитын байгууллагын хураанд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Төрийн аудитын тухай хуулийн 20.3 дахь "Дотоод аудитын эгнээд болон хяналтын бүсэд албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хураанд хэрэгжүүлэн ажил, түүний үр дүнд төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5.2.4 дахь "төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт зарцуулалт, түүний үр ашгийн байдал, хяналт төлөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч эгнээд хууль тогтоомж, захирагчийн хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, даатган гаргуулахгүй байх талаар бадгууллаа, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн албаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх хууль, журмыг хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудад тавих дотоод хяналтыг цаг хугацаанд нь хийж, үр ашгийг тооцож, үнэлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮРЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

Б.ДЭЛГЭРМАА

011041235

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn